



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

*Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны
үр дүнд хийсэн аудитын тайлан*

**ТӨРИЙН АЛБАНЫ БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН
НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ
БОЛГОХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА**

Агуулга

Аудитыг гүйцэтгэж тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт..... 2
ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй стандартын мэдэгдэл 3
Дарга, тэргүүлэх аудитор С.Төмөрхүү	Бүлэг 1. Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар ТАЗСЗ-өөс зохиосон ажил хангалттай бус байна 4
Аудитын менежер	Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийн хэрэгжилтийг үнэлж, үр дүнг тооцох шаардлагатай байна 5
Л.Эрдэнэчулуун	ТАЗ үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх талаар анхаарч ажиллах шаардлагатай байна..... 7
Ахлах аудитор Ж.Эрдэнэ	Салбар зөвлөлүүдийн хэмжээнд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн ажлын гүйцэтгэл хангалттай бус байна 7
Аудитор Л.Авирмэд	Дүгнэлт 9
Шинжээч Б.Буянхишиг	Бүлэг 2. Төрийн албанд мэргэшлийн шалгалт, удирдах ажилтны сонгон шалгаруулалтад ороогүй иргэнийг томилсон зөрчил нийтлэг байна10
Аймаг, нийслэлийн Аудитын газрын аудитор, шинжээч нар	"Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам" зөрчигдсөн байна..... 10
2014 оны 11 дүгээр сар	Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд тавигдах шаардлагыг батлах шаардлагатай байна..... 11
Уг тайланг ҮАГ-ын веб сайт-аас үзнэ үү. www.audit.mn	Мэргэшлийн шалгалт, удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтад ороогүй иргэнийг албан тушаалд томилсон тохиолдол нийтлэг байна 13
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой тодруулах зүйл байвал 261805, 262451 дугаарын утас, 323266 факсаар харилцана уу.	Зарим яам, агентлагт удирдах ажилтны сонгон шалгаруулалтад ороогүй иргэн үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байна 13
ХАЯГ: Үндэсний аудитын газар, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн Газрын 4 дүгээр байр Улаанбаатар хот 15160 Монгол Улс	Дүгнэлт 15
	Бүлэг 3. Төрийн албан хаагчийн тоо бүртгэл, төрийн байгууллагуудын хүний нөөцийн бодлого төлөвлөлтийг оновчтой болгох шаардлага байна 16
	Төрийн байгууллагууд ТАХ-ийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг үнэн зөв бодитой гаргахад анхаарах хэрэгтэй байна 16
	Төрийн байгууллагуудын хүний нөөцийн бодлого, төлөвлөлт оновчтой бус байна 18
	Дүгнэлт 19
	Холбогдох байгууллагын санал 20
	Саналд өгсөн тайлбар 22
	Зөвлөмж 23
	Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаал 24
	Хавсралтууд 25

Товчилсон үгийн жагсаалт

БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГХГЗЗГ	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар
ГХЯ	Гадаад харилцааны яам
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗТЯ	Зам тээврийн яам
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МХШҮХ	Мэдээлэл, хяналт -шинжилгээ, үнэлгээний хэлтэс
СБТГ	Стратеги, бодлого төлөвлөлтийн газар
ССАЖЯ	Соёл, спорт, аялал жуулчлалын яам
СХОХ	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс
ТАЗ	Төрийн Албаны Зөвлөл
ТАЗСЗ	Төрийн Албаны Зөвлөлийн салбар зөвлөл
ТАТХ	Төрийн албаны тухай хууль
ТАХ	Төрийн албан хаагч
ТББХ	Төрийн байгуулалтын Байнгын хороо
ТЖАХ	Төрийн жинхэнэ албан хаагч
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
УИХ	Улсын Их Хурал
УУЯ	Уул уурхайн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны шийдвэр, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний Аудитын газраас 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Төрийн албаны зөвлөл, төрийн албаны салбар зөвлөлийн /цаашид ТАЗ, ТАЗСЗ гэх/ үйл ажиллагааг шалган дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийж гүйцэтгэв. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх,
- Төрийн албаны мэргэшлийн шалгалт, төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалт хуулийн дагуу зохион байгуулагдаж буй эсэх,
- Төрийн албан хаагчийн тоо, төрийн байгууллагуудын хүний нөөцийн бодлого оновчтой байгаа эсэх.

Хамарсан хүрээ

Аудитад төрийн албаны төв байгууллага Төрийн албаны зөвлөл болон төрийн албаны зөвлөлийн яам, агентлаг, аймаг, нийслэлийн салбар зөвлөлүүдийн 2012, 2013 оны үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ гүйцэтгэлийн аудитын арга зүйг баримтлан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа гаргуулан шалгуурыг бодит байдалтай харьцуулах, статистик тоо мэдээ, судалгааны материалд шинжилгээ хийх, салбар зөвлөлийн тайланг судлах, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулан аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт

Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын тухай хууль, Яам, агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, УИХ-ын 2009 оны 87 дугаар тогтоол, Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолоор баталсан журам, ТАЗ-ийн холбогдох бусад заавар, журмыг шалгуур болгон ашиглав.

Аудитын стандартын талаарх мэдээлэл

Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журмыг баримталсан бөгөөд аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Бүлэг 1

Төрийн албаны тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар ТАЗСЗ-өөс зохиосон ажил хангалттай бус байна

Оршил

1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын тухай хууль, Яам, агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль болон УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоол, ТАЗ-ийн тогтоолоор тус тус батлагдсан заавар, журмууд төрийн албаны үйл ажиллагааны хууль эрх зүйн үндсийг бүрдүүлж байна.

1.2. УИХ-ын 2009 оны 87 дугаар тогтоолоор “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм” шинэчлэн батлагджээ.

1.3. Төрийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Төрийн албаны төв байгууллага нь “Төрийн албаны зөвлөл” мөн гэж ТАЗ-ийн статусыг тодорхойлсон ба уг хуулийн 35 дугаар зүйлд ТАЗ-ийн бүрэн эрхийг 16 асуудлаар тогтоосон байна.

1.4. Төрийн албаны тухай хуульд 2008 онд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотойгоор ТАЗ-өөс өмнө нь гаргасан журмуудыг өөрчлөн мөрдөх шаардлага үүсч, нийт 18 журам, зааврыг шинэчилсэн байна.

1.5. Улсын хэмжээнд 2013 оны байдлаар яам, агентлагт 31, аймаг, нийслэлд 22 нийт 53 төрийн албаны салбар зөвлөл төрийн албаны үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, түүнд 447 хүн орон тооны бус гишүүнээр томилогдон ажиллаж байгаагаас 105 нь салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэж байна. ТАЗ-ийн ажлын алба 15, төрийн албаны институт 5 ажилтантай байна.

1.6. ТАЗ-ийн статистик мэдээ, судалгаанаас үзэхэд 2013 оны байдлаар Монгол Улсад нийт 3994 төрийн байгууллагад 169448 ТАХ бүртгэлтэй байгаагаас улс төрийн албанд 2984, төрийн жинхэнэ албанд 50442, төрийн үйлчилгээнд 116022 хүн байгаа нь өмнөх онтой харьцуулахад байгууллагын тоо 86, ТАХ-ийн тоо 6674-өөр тус тус нэмэгджээ.

Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийн хэрэгжилтийг үнэлж, үр дүнг тооцох шаардлагатай байна

1.7. Төрийн албаны шинэтгэл нь төрийн албанд олон жилийн турш харимтлуулсан туршлагад тулгуурлан цаашид улам төгөлдөржүүлж, шинэ нөхцөл, байдалтай уялдуулан сайжруулах байнгын үйл явц юм.

1.8. Төрийн албаны шинэтгэлийн бодлого нь ТАТХ болон бусад хууль тогтоомжид тусгагдаж дараах зарчим, шаардлагыг хангахаар тодорхойлогдсон байна. Үүнд:

- Төрийн алба улс төрөөс ангид байх,
- Боловсон хүчний талаарх шийдвэр ил тод байх,
- Төрийн албанд адил тэгш эрх эдлэх,
- ТАХ-ийн үүрэг, эрх, ёс зүйн хэм хэмжээг хуулиар тогтоох,
- Хувийн орлого, өмчийн талаар мэдээлэх,
- Албан үүргийн хувьд нэг нь нөгөөдөө захирагдах буюу шууд хяналт тавих ажил, албан тушаалд гэр бүл, төрөл садангийн хүмүүс хамт ажиллахыг хориглох,
- Үйл ажиллагаагаа УИХ-д тайлагнадаг, хараат бус бие даасан ТАЗ-ийг бий болгох

1.9 Монгол Улсын Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги УИХ-ын 2004 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан боловч түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн газар 2007 онд 186 дугаар тогтоолоор баталж, төлөвлөгөөний биелэлтийн явцад дүн шинжилгээ хийж, түүний үр дүнг жил бүр Засгийн газарт танилцуулж байхыг ЗГХЭГ-ын даргад даалгасан байна.

1.10 Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газраас 2012, 2013 онд зохиосон ажлын талаар ҮАГ-т тайлан мэдээлэл ирүүлэх хүсэлтийг албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн боловч хариуг 2014




оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн ХЭГ/1778 тоот бичгээр ирүүлэхдээ стратегийг хэрэгжүүлэх талаар зохиосон ажлаа ирүүлэхийн оронд аймаг, нийслэл, яам агентлагийн 2012, 2013 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлсэн хяналт, шинжилгээ үнэлгээний тайлангаа ирүүлсэн байна.

1.11 ТАЗ нь төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн тухай товч тайлан мэдээг гаргаж 2013 оны 12 дугаар сард УИХ-ын ТББХ-нд хүргүүлжээ.

1.12 “Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги”-т ТАЗ-ийн хариуцсан үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, биелэлтийг тооцоход 13 зорилтын 45 арга хэмжээнээс 90-100 хувь биелсэн 19 арга хэмжээ, 70 хувьтай 14, 30-50 хувьтай 10, төрийн албан хаагчдын цалин хөлсний асуудлаар судалгаа хийх, мэдээллээр хангах, цалин хөлсний тогтолцоог шинэчлэх санал боловсруулах үүрэг бүхий судалгааны нэгж байгуулах гэсэн асуудал хэрэгжээгүй, биелэлтийн хувь 72.6 хувьтай байна.

1.13 Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн дүнд төрийн захиргааны байгууллагууд цахим хуудсын бүтцээ өөрчилж, холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг, шийдвэр, зар зэрэг мэдээлэлтэй иргэд тухай бүр танилцах боломжтой болж, төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтыг цахимаар авч эхэлснээр шуурхай ил тод байдал дээшилсэн, төрийн албаны чадавхийг бэхжүүлэх чиглэлээр төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх ажил шат дараатай хэрэгжиж байгаа, төрийн албаны хууль болон түүнийг хэрэгжүүлэх аргачлал, заавар журмуудыг ТАЗ-өөс шинэчлэн мөрдүүлж байгаа зэрэг нааштай үр дүн гарч эхэлсэн байна.

1.14 ТАЗ-өөс төрийн албаны шинэтгэлийг хэрэгжүүлэх, олон улсын туршлагаас суралцах, хамтран ажиллах талаар анхаарч 2013 онд 15 орны төрийн албаны төв байгууллагуудын удирдлагын төлөөлөл оролцсон “Төрийн албаны мерит тогтолцоо, туршлага сургамж, сорилт боломж” сэдэвт олон улсын чуулга уулзалтыг зохион байгуулсан нь Монгол Улсын төрийн албаны шинэтгэлд олон улсын байгууллагын туршлагыг харгалзан үзэх ач холбогдолтой арга хэмжээ болсон байна.



1.15 Гэвч төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийн хэрэгжилтийг төрийн төв байгууллага, яам, агентлаг, орон нутгийн захиргааны байгууллагууд, салбар зөвлөлүүд хэрхэн зохион байгуулж, ямар үр дүнд хүрч буйд хяналт-үнэлгээ, бодлогын шинжилгээ хийж, үр дүнг тооцох чиг үүрэгтэйгээр 2011 онд байгуулагдсан Төрийн албаны шинэтгэлийг удирдах хорооны үйл ажиллагааг 2012 оны 9 дүгээр сараас зогсоосон байна.

1.16 ТАЗ-ийн ажлын алба, Удирдлагын академийн хамтарсан багаас 2013 онд хийсэн төрийн албаны шинэтгэлийн хэрэгжилтийн явцын үр дүнг иргэдээр үнэлүүлсэн судалгааны дүнгээс үзэхэд төрийн албаны шинэтгэлийн хэрэгжилтийг 37.1 хувь нь дунд зэрэг, 32.5 хувь нь хангалтгүй, 6.9 хувь нь огт хангалтгүй гэж үнэлсэн байна¹.

1.17 Бүх яам, агентлагт шинэтгэлийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр төлөвлөгөө гаргаж ажиллаагүй, ТАЗ-өөс ч яам, агентлагийн ТАЗСЗ-ийн 2012, 2013 оны үйл ажиллагааг үнэлэх үзүүлэлтдээ төрийн албаны шинэтгэлийн хэрэгжилтийн талаар хийсэн ажлыг үнэлэх үзүүлэлт шалгуур оруулаагүй байна.

1.18 Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагаанд АНАГ-аас хийсэн аудитын дүнгээр 10 аймагт төрийн албаны шинэтгэлийн бодлого болон хүний нөөцийн бодлогын хэрэгжилт хангалтгүй, ТАХ-ийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг үнэн зөв гаргаж мэдээлэхгүй байна гэж үнэлэгджээ. /Хавсралт 1- ийг үзнэ үү/

1.19 Төрийн албанд шударга ёсыг эрхэмлэх, төрийн албыг улс төрөөс хараат бус байлгаж, мерит² тогтолцоог жинхэнэ ёсоор хэрэгжүүлэх асуудлууд төрийн албаны шинэтгэлээс иргэдийн хүлээж буй гол асуудал боловч тунхаглал төдий шинжтэй хэвээр байна.

1.20 ТАЗ-өөс 2013, 2014 онд бүх яам, агентлаг, аймаг, нийслэлийн салбар зөвлөлүүдэд ажлын хэсэг ажиллуулж, ТАЗ-ийн даргын баталсан удирдамжаар зөвлөн туслах ажил зохион байгуулж, салбар зөвлөл бүрийн ажлын зохион байгуулалтад гарсан асуудлаар зөвлөмж, чиглэл өгч ажилласан байна.

1.21 Гэхдээ Монгол Улсын төрийн албаны бүтэц өргөжиж, төрийн албан хаагчийн тоо, бүрэлдэхүүн хөдөлгөөн жилээс жилд өссөөр ирсэн боловч төрийн албаны төв байгууллага ТАЗ өнөөгийн байдлаар бүтэц зохион байгуулалтын хувьд төрийн

¹ Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны тайлан 2013 он

² Мерит тогтолцоо нь төрийн албыг мэргэшсэн, тогтвортой хамгийн гол нь улстөрийн нөлөөллөөс ангид байлгахад чиглэдэг.

албаны стандартын удирдлагыг бүрэн хэрэгжүүлэх, үүргээ биелүүлэх боломж нь санхүү болон хүний нөөцийн хувьд дутагдалтай байна.

ТАЗ-өөс чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх талаар анхаарч ажиллах шаардлагатай байна

1.22 ТАТХ-ийн 35 дугаар зүйлээр тодорхойлогдсон ТАЗ-ийн бүрэн эрхийн хэрэгжилтэд үнэлгээ хийж үзэхэд 71.3 хувийн биелэлттэй гарч, бүрэн эрхийн 15 асуудлаас 90-100 хувьтай 5, 70 хувьтай 7, 50 хувьтай 2, 30 хувьтай хэрэгжсэн нэг асуудал байна.

1.23 ТАЗ-өөс төрийн байгууллагын өөрчлөлт, хөгжлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хүний нөөцийн төлөвлөлтийн арга зүйн удирдлагаар хангах, төрийн жинхэнэ албаны боловсон хүчний хэрэгцээг төлөвлөх, хангалтыг зохион байгуулах, төрийн албатай холбогдсон судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулах, зохицуулах талаар бодлогын тодорхой асуудлыг зангидаж зохион байгуулсан зүйл харагдахгүй байна.

1.24 ТАЗ-ийн үйл ажиллагаанд одоо мөрдөгдөж байгаа дүрэм, журам, тогтоолд хүчингүй болсон “Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай” хуулийн заалтыг үндэслэсэн заалтууд байгааг цаг үетэй нь нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.

1.25 ТАЗ-өөс УИХ, Засгийн газарт төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг боловсруулан батлахад санал өгөх эрхтэй бөгөөд 2012, 2014 онуудад Засгийн газар болон яам, агентлагийн бүтцийн өөрчлөлтийн асуудлаар ТАЗ-ийн саналыг аваагүй байна.

1.26 ТАЗ нь төрийн байгууллагын төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангах, түүнд шаардагдах төсөвт зардлыг нэгтгэн тооцож Сангийн яаманд хүргүүлдэг боловч хөтөлбөрүүдийн санхүүжилт батлагддаггүйгээс хэрэгжилт сул байна.

1.27 Төрийн албаны чадавхийг бэхжүүлэх чиглэлээр гадаад орон, олон улсын байгууллагаас төрийн албанд олгож буй зээл, тусламжийн хүрээнд хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг судлан боловсруулж, тэдгээрийн давхардлыг арилгах, үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажил хийгдээгүй байна.

Салбар зөвлөлүүдийн хэмжээнд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн, ажлын гүйцэтгэл хангалттай бус байна

1.28 ТАЗ-ийн 2013 оны 128 дугаар тогтоолоор ТАЗСЗ-ийн ажиллах журам шинэчлэгдэн батлагдаж, яам, агентлаг, аймаг, нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх нийтлэг 11 чиг үүргийг тодорхойлжээ.

1.29 ТАЗСЗ-үүд орон тооны бусаар ажиллаж дарга, нарийн бичгийн дарга, гишүүд нь үндсэн ажилтайгаа хавсран гүйцэтгэж, ажлын ачаалал ихтэй байгаагаас, шинэтгэлийн бодлогын чиглэлээр оновчтой, бодитой ажил төлөвлөж хэрэгжүүлэх ажил хүлээгдэж буй үр дүнтэй харьцуулахад хангалтгүй байна.

1.30 ТАЗСЗ-ийн дарга нь зөвлөлийн гишүүдийн ажлын чиг үүргийг баталсан боловч гишүүд тухайн жилд үүргээ хэрхэн хэрэгжүүлсэн талаар яам, агентлагийн салбар зөвлөлүүд хуралдаанаараа авч хэлэлцэн тэдний ажилд нь үнэлэлт, дүгнэлт хийж, үүрэг чиглэл өгч ажилласан баримт алга байна.

1.31 Яам, агентлагийн ТАЗСЗ-өөс 2013, 2014 онд төлөвлөсөн үйл ажиллагааг авч үзэхэд салбарын хэмжээнд төрийн албаны шинэтгэл, төрийн боловсон хүчний бодлогыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулахад мэргэжлийн зөвлөгөө, арга зүйн туслалцаа үзүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохиох зэргээр үндсэн чиг үүргийг бүрэн хамруулах талаар бодитой ажлууд цөөн байна.

1.32 Ихэнх салбар зөвлөлийн төлөвлөгөөнд ТАХ-дад зэрэг дэв олгох, удирдах ажилтны сонгон шалгаруулалт явуулах, дүгнэлт гаргах, төрийн албаны шалгалт зохион байгуулах, ТАХ-тай холбоотой гомдол маргааныг хэлэлцэх, төрийн одон медалиар шагнуулах, үр дүнгийн гэрээний биелэлт, ёс зүйн хорооны тайланг авч хэлэлцэх зэрэг асуудал тусгаж, ТАТХ, тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар ТАЗ-өөс зохиосон ажил хангалттай бус байна.

1.33 Яамдын ТАЗСЗ-ийн гишүүдийн болон удирдах ажилтнуудын ТАХ-ийн хувийн хэргийг ТАЗ-ийн 18 дугаар тогтоолоор баталсан зааврын дагуу бүрдүүлсэн эсэхийг шалгахад бүрдэлт дутуу байсан тул нөхөн бүрдүүлэлт хийж, ажилтнуудын хувийн хэрэгт үзлэг зохион байгуулж цэгцлэх нь чухал байна.

1.34 ТАЗ 2013 онд ТАЗСЗ-ийн үйл ажиллагааг 200 оноогоор үнэлсэн бөгөөд ЭЗХЯ, ГХЯ, ССАЖЯ, ЭМЯ-ны дэргэдэх салбар зөвлөл, ТЕГ, ТӨХ-ны дэргэдэх салбар зөвлөл, аймаг, нийслэлийн ТАЗСЗ-ийг 150 оноогоор үнэлэхэд Сүхбаатар, Дархан-Уул, Хэнтий, Төв аймгийн салбар зөвлөлүүдийн үйл ажиллагаа бусдаас доогуур үзүүлэлттэй гарсан байна.

Салбар зөвлөлүүдийн 2012 оны үйл ажиллагааны үнэлгээгээр Завхан, Говь-Алтай, Сүхбаатар, Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх газар, Татварын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх ТАЗСЗ-үүд хангалтгүй үнэлэгдсэн байна.

1.35 Аймаг, нийслэлийн ТАЗСЗ-үүдэд хийсэн шалгалтын дүнгээр салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой 58, төрийн албаны мэргэшлийн шалгалт, төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалт, орон тоотой холбоотой 857 зөрчил, дутагдал илэрч тэдгээрт 38 төрлийн дүгнэлт хийж, 6 үндсэн асуудлыг засаж сайжруулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд 33 зөвлөмж өгсөн байна. / Хавсралт 2-ийг үзнэ үү/

Дүгнэлт:

- Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийн хэрэгжилтийг Засгийн газар болон ТАЗ-ийн хэмжээнд тооцож, үр дүнг үнэлэн УИХ-аас цаашид холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх бодит хэрэгцээ шаардлага байна.
- Төрийн албаны хууль эрх зүйн шинэ орчныг бүрдүүлэх талаар анхаарч, хуулиудын уялдаа холбоог судлан санал боловсруулж, цогцоор нь шийдвэрлэх зайлшгүй шаардлага бий болжээ.
- Төрийн албаны тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар ТАЗСЗ-өөс зохиосон ажил хангалттай бус байна.
- ТАЗ-ийн бүрэн эрхийн хэрэгжилтэд үнэлгээ хийж үзэхэд 71.3 хувийн биелэлттэй байна
- ТАЗ-ийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхүйц бүтэц, зохион байгуулалт, санхүү, хүний нөөцөөр хангах шаардлага байна.
- ТАЗ-өөс салбар зөвлөлийг төрийн байгууллагын өөрчлөлт, хөгжлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хүний нөөцийн төлөвлөлтийн арга зүйн удирдлагаар хангах, төрийн жинхэнэ албаны боловсон хүчний хэрэгцээг төлөвлөх, хангалтыг зохион байгуулах, төрийн албатай холбогдсон судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулах, зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлэх талаар зохиосон ажил хангалттай бус байна.
- ТАЗСЗ-үүд ТАТХ-ийг хэрэгжүүлэх чиглэлээр харьяа байгууллагад мэргэжил арга зүйн туслалцааг үзүүлж ажиллах талаар төлөвлөсөн ажлаа эрчимжүүлэх шаардлагатай байна.
- ТАЗСЗ-үүдийн үйл ажиллагааны үр дүн доогуур үзүүлэлттэй гарсан байна.

Бүлэг 2

Төрийн албанд мэргэшлийн шалгалт, удирдах ажилтны сонгон шалгаруулалтад ороогүй иргэнийг томилсон зөрчил нийтлэг байна

2.2 ТАЗ-ийн 2012 оны тайлан мэдээнээс үзэхэд 2012 онд төрийн жинхэнэ албаны захиалгатай 1065 сул орон тоонд 6280 иргэн бүртгүүлж 3647 иргэн тэнцсэнээс 1207 иргэн томилогдож, 2440 иргэн нөөцөд оржээ.

2.3 2013 онд 1489 ажлын байрны захиалгад 9732 иргэн өрсөлдөж, 1999 хүн шалгалтад тэнцсэнээс 1073 нь томилогдож, 926 иргэн нөөцөд бүртгэгдсэн бол төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын 80 орон тоо зарлагдахад 131 хүн бүртгүүлж, 110 нь тэнцэн 76 хүн томилогдож, 34 нь нөөцөд орсон байна³.

2.4 Засгийн газрын 2012 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн ээлжит бус хуралдаанаар яамдын ТНБД нарыг ажлаас чөлөөлж, үүргийг түр орлон гүйцэтгэгч нарыг шууд томилсон нь ТАТХ тогтоомжийг зөрчсөн гэж үзэж асуудлыг ТАТХ бусад хууль эрх зүйн актын дагуу шийдвэрлэж, хууль зүйд нийцүүлэх тухай саналыг ТАЗ-ийн даргын 2012 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн 683 тоот албан бичгээр Ерөнхий сайдад, мөн оны 9 дүгээр сарын 18 –ны өдрийн 705 тоот бичгээр ЗГХЭГ-т, 2013 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 343 тоот бичгээр тус тус хүргүүлж байсан байна.

2.5 Мөн Агентлагийн дарга нарын томилгооны асуудлаар ТАЗ-ийн даргын 2013 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 116, 4 дүгээр сарын 9-ний өдрийн 344 тоот албан бичиг хүргүүлж байжээ.

“Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам” зөрчигдсөн байна

2.6 Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхтэй холбогдсон харилцааг ТАТХ-ийн 21 дүгээр зүйл болон түүнд нийцүүлэн Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам”-аар зохицуулсан бөгөөд Засгийн газрын 2012 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 26 дугаар тогтоолоор дээрх журамд оруулсан нэмэлт нь ТАТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.1 заалттай зөрчилдөж, ТЖАХ-ийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх заалтыг төрийн жинхэнэ албанд түр томилох заалт болгон өөрчилсөн байна⁴.

2.7 ЗГХЭГ-аас 2013 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн ХЭГ/66 тоот албан бичгээр ТАЗ-д захиалгаа хүргүүлж, зарласан ажлын байранд 21 иргэн бүртгүүлснээс БОНХЯ, БШУЯ, ХЯ, ХАХНХЯ, ҮХААЯ-ны ТНБД нарын ажлын байранд тус бүр 2, бусад 11 ажлын байранд тус бүр нэг иргэн бүртгүүлж, сонгон шалгаруулалтыг ТАЗ-ийн даргын 2 дугаар сарын 21-ний өдрийн 12 тоот тушаалаар байгуулагдсан комисс зохион байгуулж, шалгаруулалтад тэнцсэн 20 иргэнээс 4 хүнийг удирдах ажилтны нөөцөд

³ ТАЗ-ийн 2012, 2013 оны үйл ажиллагааны тайлан

⁴ ТАТХ-ийн 21.1-д Төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан ТЖАХ-тай тохиролцсоны дагуу албан үүргийнх нь зэрэгцээ эзгүй байгаа албан хаагчийн үүргийг түр орлон гүйцэтгүүлж болно

бүртгэн 16 иргэнийг тухайн албан тушаалд нэр дэвшүүлж, томилуулах саналаа ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.

2.8 ТАЗ-ийн санал дүгнэлтийг үндэслэн Засгийн газар 15 яамны ТНБД-ыг томилж, Хөдөлмөрийн яамны ТНБД-д нэр дэвшсэн иргэнийг томилоогүй бөгөөд энэ албан тушаалд өнөөг хүртэл түр орлон гүйцэтгэгч ажиллаж, 2013 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 344 тоот бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн ТАЗ-ийн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

2.9 Хуульд нийцсэн томилгоог хийх, сонгон шалгаруулалтын талаар ТАЗ-өөс өгсөн зөвлөмжийн дагуу ЗГХЭГ-аас нийт 14 агентлагийн дарга нарын ажлын байрны сонгон шалгаруулалтын захиалгыг Засгийн газар байгуулагдсанаас хойш 5 сарын дараа ТАЗ-д ирүүлснээр бүртгүүлсэн 23 иргэнээс шалгаруулалтад 18 хүн тэнцэж, 13 иргэнийг нэр дэвшүүлэн томилуулах санал хүргүүлж, 5 иргэнийг удирдах ажилтны нөөцөд бүртгэсэн ба ТЕГ-ын дарга түр томилгоотой хэвээр байна.

2.10 Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 145 дугаар тогтоолоор дээрх 26 дугаар тогтоолыг хүчингүй болгосон байна.

Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд тавигдах шаардлагыг батлах шаардлагатай байна

2.11 ТАЗ-өөс төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд тавигдах шаардлагын төслийг боловсруулан УИХ-ын холбогдох Байнгын хороонд 2012 оны 12 дугаар сард хүргүүлсэн боловч холбогдох шатанд хэлэлцэгдээгүй байна⁵.

2.12 Батлагдсан ийм стандарт байхгүйгээс тухайн томилогдох хүнд зориулсан шаардлага боловсруулдаг тохиолдол ажиглагдав.

2.13 Тухайлбал,

- *БХБЯ-ны хэрэгжүүлэгч агентлаг ГХГЗЗГ-ын дарга МХШҮХ-ийн даргын ажлын байрны тодорхойлолтод албан тушаалд тавигдах ерөнхий шаардлагад төрийн албанд 8 жил үүнээс тухайн мэргэжлээр 5 жил ажилласан докторын цол зэрэгтэй иргэн байх шаардлага анх баталсан байсан бол дараа нь өөрчилж шинээр ерөнхий шаардлагын ажлын туршлага хангаагүй, төрийн алба хааж байгаагүй тухайн жил их сургууль төгссөн иргэнд зориулсан ажлын байрны тодорхойлолт боловсруулсан. Ингэснээр уг иргэн хэлтсийн даргын албан тушаалд өрсөлдөж ярилцлагын оноогоор бусад шалгуулагчдаас хамгийн өндөр үнэлгээ авч шалгаруулалтад тэнцэн албан тушаалд томилогдсон байна.*
- *БОНХЯ 2013 оны 3 дугаар сарын 28-ны 3/1346 тоот албан бичгээр ТАЗ-д Төрийн захиргаа удирдлагын газрын, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын, Ногоон хөгжлийн, бодлого төлөвлөлтийн газрын даргын, Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын даргын ажлын байрны сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулах захиалгыг өгчээ. Үүнд: Уг албан тушаалыг хашиж байсан өмнөх даргын ажлын байрны тодорхойлолттой харьцуулахад гүйцэтгэх чиг үүрэг нь адил, тавигдах*

⁵ ТАТХ-ийн 33 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт: ТЖА-ны удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг ТА-ны төв байгууллагын саналыг үндэслэн УИХ тогтооно гэж заажээ

шаардлагад төрийн захиргааны удирдлагын буюу байгаль хамгааллын мэргэжилтэй, төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан, үүний дотор удирдах албан тушаалд 1-ээс доошгүй жил ажилласан байх гэсэн шалгуур тавигдаж байжээ. Гэтэл 1 хоногийн дараа буюу 2013 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 3/1365 тоотойр ТАЗСЗ-өөр хэлэлцэж ажлын байранд тавигдах шаардлагад өөрчлөлт оруулсан байдлыг харахад эрх зүйч, Удирдахуйн ухааны (төрийн бизнесийн, нийгмийн) Ажлын туршлагад ТББ, хувийн хэвшилд удирдах албан хашсан, 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай гэж өөрчилжээ.

- *ҮХААЯ-ны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргад нэр дэвшүүлэхдээ ажлын байрны шаардлага хангаагүй, мэргэжлийн бус иргэнийг томилуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал болгосноор томилгоо хийгдсэн нь Төрийн захиргааны төв байгууллагууд хуулиа зөрчиж шударга бус үйл ажиллагаа явуулсан байна.*
- *ҮХААЯ-ны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын, ССАЖЯ-ны Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын бодлого хариуцсан мэргэжилтний албан тушаалд ажлын байрны тодорхойлолтын ерөнхий шаардлагад нийцээгүй иргэнийг тус тус авч ажиллуулсан байна.*
- *ССАЖЯ дотоодын аялал жуулчлалын асуудал хариуцсан, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын бодлого зохицуулалтын асуудал хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтын ерөнхий шаардлагад мэргэшил, туршлага, мөн олон нийттэй харилцах мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод мэргэшлийг тус тус зааж өгөөгүй байна*
- *БОНХЯ ТАЗ-ийн дүгнэлтээр нэр дэвшүүлсэн иргэдийг томилоогүй, шалгалтанд тэнцээгүй, иргэнийг нэр дэвшүүлж томилсон, шалгалтанд эхний байрт орсон иргэнийг томилогүй нөөцөд бүртгэгдсэн иргэнийг газрын даргын албан тушаалд түр томилсон байна.*
- *ТАЗ-өөс Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын даргын ажлын байранд сонгон шалгаруулалт явуулж , тэнцсэн иргэдийн дүгнэлтийг хүргүүлсэн боловч Төсвийн ерөнхийлөн захирагч уг иргэдийг томилоогүй бөгөөд ТАЗ 2013 оны 82 дугаар тогтоолоор эхний байрт орсон иргэнийг удирдах албан тушаалтны нөөцөд бүртгэгдсэн тухай шийдвэр болгон өөрчилсөн байна.*
- *Ингэснээр Төрийн албаны зөвлөл нь “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 1.4-д заасан ТАЗ нь хамтын удирдлагын зарчмыг удирдлага болгон хараат бус бие даасан байдлаар үйл ажиллагаа явуулна гэсэн заалтыг өөрөө зөрчсөн байна.*

Мэргэшлийн шалгалт, удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтад ороогүй иргэнийг албан тушаалд томилсон тохиолдол нийтлэг байна

2.14 АНАГ-аас ТАЗСЗ-үүдэд хийсэн тайлангийн нэгтгэлээс үзэхэд ТАЗСЗ-ийн үйл ажиллагаа болон төрийн албаны мэргэшлийн шалгалт, удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулаагүй, хууль бус томилгоотой холбоотой 857 тохиолдол бүртгэгдсэн байна. /Хавсралт 1-ийг үзнэ үү/

2.15 Аймгуудын дүнгээр удирдах ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэгчээр 76, сонгон шалгаруулалтгүй ажилд орсон 68 удирдах ажилтан ажиллаж, Говь-Алтай, Завхан, Сэлэнгэ, Дорноговь, Архангай, Өмнөговь, Төв аймагт төрийн албаны мэргэшлийн шалгалтад ороогүй 129, тэнцээгүй 65 иргэнийг төрийн албаны гүйцэтгэх албан тушаалд томилсон нь ТАТХ болон ТАЗ-ийн 2013 оны 86 дугаар тогтоолыг тус тус зөрчсөн байна. Тухайлбал,

2.16 Булган, Дорноговь зэрэг аймгуудад сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга, зарим агентлаг болон төсвийн байгууллагын дарга нарыг сонгон шалгаруулалтгүйгээр ажилд томилсон бол Архангай, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Дундговь, Өвөрхангай зэрэг аймагт 76 хүн түр орлон гүйцэтгэгчээр томилогдон ажиллаж, Говь-Алтай аймагт хамгийн олон буюу 54 түр орлон гүйцэтгэгч ажиллаж, сонгон шалгаруулалт хийгдээгүй өнөөг хүрсэн байна.

2.17 Мөн аймаг, нийслэлд ажлын байрны тодорхойлолтын ерөнхий болон тусгай шаардлагыг хангаагүй 97 иргэн төрийн албанд томилогдсон байна.

2.18 Архангай аймагт сумын ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдсон 11, аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдсон 5 нийт 16 иргэн төрийн жинхэнэ албанд ажиллаж байгаа нь ТАТХ-ийн 15.1.8-д заасан ТЖАХ-ийн үйл ажиллагаанд хориглох тухай заалтыг зөрчсөн байна⁶.

2.19 Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны томилгоо, сонгон шалгаруулалттай холбоотой хууль тогтоомжийг зөрчиж байгаа ТАЗСЗ дээр ТАЗ-өөс яаралтай үзлэг, шалгалт хийж, зөрчлийг арилгах, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх шаардлага байна.



Зарим яам, агентлагт удирдах ажилтны сонгон шалгаруулалтад ороогүй иргэн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байна

2.20 Аудитын судалгааны дүнгээс үзэхэд 2012 онд улсын хэмжээнд төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд үүргийг түр орлон гүйцэтгэгчээр 463 иргэн томилогдсон байсан бол 2013 онд 121 иргэн байгаагаас 76 нь аймаг, нийслэлд, 45 нь яам, агентлагт ажиллаж байгаа нь УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолын 38 дах заалт, Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолыг тус тус зөрчсөн байна⁷.

⁶ Аймаг, нийслэл сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдох, аж ахуйн нэгж, нам олон нийтийн бусад байгууллагад орон тооны албан тушаал хавсран гүйцэтгэх

2.21 Сонгон шалгаруулалтаар шалгарсан хүмүүсийг томилоогүй бол томилох эрх бүхий этгээдэд хариуцлага хүлээлгэх арга хэмжээг Төрийн албаны тухай хуульд торгууль ногдуулж хариуцлага хүлээлгэхээр заасан боловч ямар ч байгууллагад арга хэмжээ авч байсан талаар баримт алга байна.

2.22 Хууль бус томилгоо хийсэн, сонгон шалгаруулалтад ороогүй иргэнийг томилсон зэргээр ТАТХ зөрчсөн эрх бүхий этгээдийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлж тодорхой арга хэмжээ авахуулах ажлыг ТАЗ хийгээгүй байна.

2.23 ТАЗ төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалттай холбоотой гомдол, маргааныг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй.

2.24 ТАЗ-ийн ТАЗСЗ-үүдэд 2012 онд 239 өргөдөл гомдол ирсэн бөгөөд 234 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэснээс 16 өргөдлийг ТАЗ-өөс маргаан хянан шийдвэрлэх комисс томилж шийдвэрлэсэн байна.

2.25 2013 онд нийт ТАЗСЗ-ийн хэмжээнд 395 гомдол, маргаан бүртгэгдсэн нь өмнөх оноос 65.3 хувиар өссөн бөгөөд ажлаас үндэслэлгүй халагдсантай холбогдсон маргаан 124, төрийн жинхэнэ албаны сонгон шалгаруулалт, дүгнэлт, нөөц, томилгоотой холбогдох 66, мэргэшлийн шалгалтын 79, ТАХ-ийн ёс зүйтэй холбоотой 40, бусад 86 асуудлаар бүртгэгджээ.

2.26 Эдгээрээс үндэслэлгүйгээр албан тушаал бууруулсан маргаан 1, ажлаас үндэслэлгүй халсан 4, нийт 5 гомдлыг ТАЗ-өөс хянан шийдвэрлэсэн байна.

2.27 ТАЗ төрийн албаны мэргэшлийн шалгалтын хураамжийг бэлнээр авч зарцуулах, тариф тогтоосон нэгдсэн шийдвэр байхгүй, нягтлан бодох бүртгэлээс гадуур бүртгэгдсэн зэрэг зөрчил 2012 онд нэлээд гарч байсан бөгөөд 2013 онд аймаг, нийслэлийн дүнгээр шалгалтын төлбөр хураамжтай холбоотой 30.9 сая төгрөгийн зөрчил илэрч 15.8 сая төгрөгийн төлбөрийн акт бичигдэж, 15.0 сая төгрөгийн албан шаардлага өгөгдсөн болно.

2.28 Энэ нь сонгон шалгаруулалт зохион байгуулах зардал ТАЗ-ийн төсөвт тусгагддаггүйгээс ТАЗ-ийн 2009 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-д мэргэшлийн шалгалттай холбоотойгоор гарах зардлыг шалгуулагчдаас хураамж хэлбэрээр авч байгаа тул цаашид эрх зүйн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх шаардлагатай юм.

2.29 УАГ-аас 2010 онд “Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан төрийн албан хаагчдын сонгон шалгаруулалт, түүний үр дүн”-д хийсэн аудитаар мэргэшлийн шалгалт, сонгон шалгаруулалтад ороогүй иргэнийг албан тушаалд томилох, ТАЗ-өөс санал болгосон нэр дэвшигчийг ажилд томилоогүй байх, ТАЗСЗ-үүдийн үйл ажиллагаанд гарч буй нийтлэг алдаа дутагдал энэхүү аудитаар давтагдан гарч байна⁷.

⁷ УАГ-аас 2010 онд “Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан төрийн албан хаагчдын сонгон шалгаруулалт, түүний үр дүн” сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудит

Дүгнэлт:

- Яам, агентлагийн төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтныг томилоход ТАТХ болон УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоол, Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоол, ТАЗ-өөс баталсан журмыг зөрчих тохиолдол нийтлэг гарсан, ТАЗ-ийн санал дүгнэлт гаргахгүйгээр үүргийг түр орлон гүйцэтгэгч томилсон, төрийн албанд жинхлээгүй иргэн үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллуулсан зөрчил байна.
- Эдгээр зөрчил дутагдалтай холбогдуулан төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалт, томилгоотой холбоотой асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэх саналыг ТАЗ-өөс Засгийн газарт удаа дараа тавьсан бөгөөд зөрчил дутагдлыг арилгах, хууль журмыг дагаж мөрдөх ажил удаашралтай, хүндрэл бэрхшээлтэй тулгарч байна.
- ТАЗ-өөс хуульд заасны дагуу төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны ажлын байранд тавигдах шаардлагын төслийг боловсруулан УИХ-д хүргүүлсэн боловч батлагдаагүй байна. Иймээс удирдах ажилтны нэгдсэн стандарт тогтоогүй, улмаар томилогдох хүнд тохирсон шаардлага боловсруулдаг үзэгдэл бий болсон байна.
- ТАЗ-ийн “ТАЗСЗ-ийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг батлах” тухай 2013 оны 105 дугаар тогтоол нь томилох эрх бүхий этгээдийн нөлөөнд автах, ашиг сонирхлын зөрчил үүсгэх, ТАТХ зөрчигдөх нөхцлийг бий болгож байна.
- Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны томилгоо, сонгон шалгаруулалт, мэргэжлийн шалгалттай холбоотой гарч буй зөрчил дутагдлыг арилгах, засаж залруулах талаар ТАЗ хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хангалттай хэрэгжүүлээгүй байна.
- Төрийн албаны үйл ажиллагаатай холбоотой өргөдөл хүсэлт, гомдол, маргааны тоо буураагүй бөгөөд 2013 онд өмнөх оноос 65.3 хувиар өссөн байна.

Бүлэг 3

Төрийн албан хаагчийн тоо бүртгэл, төрийн байгууллагуудын хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох шаардлага байна

Оршил

3.1 Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний талаарх статистикийн тоо мэдээг ТАЗ жил бүр хуулийн дагуу үнэн зөв гаргах үүрэгтэй.

3.2 Улсын хэмжээнд төрийн албан хаагчийн тоо, бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрэн төлөвшөөгүй, Сангийн яам, ТАЗ-ийн түвшинд төрийн албан хаагчдын орон тооны талаарх мэдээлэл хоорондоо зөрүүтэй гарч байна.

3.3 ТАЗ-өөс энэ талаар 2014 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр 1397 тоот бичгээр ирүүлсэн тайлбараас үзэхэд оны эхэнд төсөвт батлагдсан орон тоо 176773 байсан бол оны эцэст 169448 албан хаагч бүртгэгдэж, зөрүү нь 7325 гарсан байна. Үүнээс:

3.4 Улсын төсвийн гүйцэтгэлийн тайланд туссан боловч ТАЗ-ийн тайланд хамрагдаагүй 55 байгууллагын 3020 албан хаагч, гэрээт ажилтан 1134, давхар ажил үүрэг гүйцэтгэж байгаа 2074, тоо бүртгэлийн үед сул байсан болон цомхотгогдсон орон тоо 1097 байсан судалгаа гарсан байна.

3.5 Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүнд эрүүл мэнд, боловсрол, шинжлэх ухааны салбарын 92286 хүн ажиллаж, нийт төрийн албан хаагчдын 86 хувийг эзэлж байна.

Төрийн байгууллагууд ТАХ-ийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг үнэн зөв бодитой гаргахад анхаарах хэрэгтэй байна

3.6 Төрийн албан хаагчдын статистик судалгаанаас үзэхэд 2010 онд нийт төрийн албан хаагчдын тоо 155679 байсан бол 2013 онд 169448 болж, 13769-өөр нэмэгдсэн байна.

Хамарсан он	2010	2011	2012	2013
Нийт	155679	161612	162769	169448
Улс төрийн албан хаагч	2907	2987	2798	2984
Жинхэнэ албан хаагч	43290	46082	44957	50442
Үйлчилгээний албан хаагч	109482	112543	115019	116022

ТАХ-ийн тооны өөрчлөлтийг бүрэлдэхүүнээр харуулахад 2013 онд улс төрийн албан хаагч 186 хүнээр, төрийн жинхэнэ албан хаагчийн тоо 5485 хүнээр, үйлчилгээний ажилтны тоо 1003 хүнээр өмнөх оноос тус тус өссөн үзүүлэлт гарч байна. /Хүснэгт

1-ийг үзнэ үү /

3.7 Аудитын явцад авсан ТАХ-ийн тоо мэдээг ТАЗ-ийн 2013 оны мэдээтэй харьцуулан авч үзэхэд Архангай, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Ховд зэрэг аймаг болон төрийн захиргааны төв байгууллагууд

5811 хүнээр дутуу, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Орхон, Төв, Увс, Хөвсгөл, Хэнтий аймгууд 7724 хүнээр илүү байгаа судалгаа гарган ирүүлсэн байна.

3.8 Үүний шалтгааныг нягтлан судалж, 2014 оноос тайлан мэдээнд бодитой тусгах шаардлагатай байна.

3.9 Тээврийн хэрэгслийн оношлогоо, хяналт зохицуулалтын төвийн 490, Төр засгийн үйлчилгээ авто бааз, аж ахуй эрхлэх газрын 425, боловсролын байгууллагын 262, ИНЕГ-ын 127, Засгийн газрын байруудын ашиглалтын нэгдсэн захиргааны 167, дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газрын 178 бусад байгууллагын 1371 нийтдээ 3020 хүний мэдээг аж ахуйн тооцоот болон төсөвт үйлдвэрийн газрын албан хаагч гэсэн үндэслэлээр төрийн албаны аль ч ангилал зэрэглэлд үл хамааруулан нэгдсэн тоо бүртгэл, мэдээлэлд оруулаагүй байна.

3.10 Энэ нь ойролцоогоор 21.7 тэрбум төгрөгийн цалингийн сангийн асуудал бөгөөд эдгээр хүмүүсийг төрийн албаны ямар ангилал зэрэглэлтэй адилтган цалинжуулж байгааг холбогдох байгууллагууд нарийвчлан авч үзэх шаардлагатай байна.

3.11 ТАЗ-өөс уг асуудлыг цаашид нэг мөр болгон бүртгэлд хамруулах эсэх асуудлыг тодорхой болгох арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

3.12 Мөн 2074 хүн яам, агентлаг, төсөл хөтөлбөр, төрийн өмчит аж ахуйн нэгжийн төлөөлөн удирдах зөвлөлд давхар албан тушаал хашиж байгаа нь төсөвт цалингийн зардлыг нэмэгдүүлэх үндэс болсон байна.

3.13 Стандартчлал, хэмжил зүйн газар 249, Архивын ерөнхий газар 161, ГХГЗЗГ 220 хүнээр зөрүүтэй тайлан гаргасан дутагдал гаргасан байхад дээрх байгууллагуудын удирдлагад ТАЗ-өөс хариуцлага тооцоогүй байна.

3.14 Эндээс үзэхэд ТАЗ-ийн тоо бүртгэлийн програм хангамжийг улам боловсронгуй болгоход анхаарч, тайлан мэдээ гаргалт, үнэн зөв, чанартай бус байж түүнд үндэслэн аливаа бодлого шийдвэр гаргаж чадахгүй байгаа нь харагдаж байна.

3.15 Нөгөө талаас төрийн байгууллага яам, агентлагт төрийн жинхэнэ албаны мэргэжлийн үйл ажиллагаа, албан тушаалд 650 гэрээт ажилтан ажиллуулан төсвөөс цалинжуулж байгаа нь орон тоо хэтрүүлэх, төсөвт цалингийн зардлын хэмжээг өсгөх, хүний нөөцийн тоо мэдээг зөрүүтэй болгох үндэс болж байна.

3.16 Нийслэлийн төр захиргааны болон түүний харьяа төсвийн байгууллагуудад 2013 оны мэдээгээр нийт 26857 ТАХ ажиллаж байгаагаас ТАЗСЗ нь төрийн захиргааны 4557 ТАХ-ийн мэдээ тайланг нэгтгэн гаргаж ТАЗ-д хүргүүлсэнээр нийслэлийн төрийн үйлчилгээний болон төрийн тусгай албан хаагч 22300 хүний мэдээ харьяа дээд байгууллагын салбар зөвлөлийн тоонд нэгтгэгдсэн байна.

3.17 ТАЗ-өөс төрийн албан хаагчийн иж бүрэн тооллогыг 2007 оноос хойш улсын хэмжээнд хийгээгүй бөгөөд тоо бүртгэлийн өнөөгийн тогтолцоог сайжруулах, ТАХ-ийн тоог бодитой гаргаж, цаашид авах арга хэмжээний санал, дүгнэлт боловсруулах нөхцөл байдал үүссэн нь харагдаж байна.

Төрийн албаны хүний нөөцийн бодлого, төлөвлөлт оновчтой бус байна

3.18 Яамдын ТАЗСЗ-үүдэд хүний нөөцтэй холбоотой төрөл бүрийн судалгаа байгаа боловч тэдгээрт үндэслэгдсэн бодлого зохицуулалтын шийдвэр гарахгүй байна.

3.19 Аудитад хамрагдсан яамдад “Хүний нөөцийн сургалтын хөтөлбөр”, “Ажилтнуудын нийгмийн хамгааллын хөтөлбөр” зэрэг баримт бичгийг боловсруулсан байгаа хэдий ч эдгээр нь хэрэгжүүлэх санхүүгийн нөөцөөр баталгааждаггүйгээс хүний нөөцийн бодлогыг бүхэлд нь оновчтой тусгасан төлөвлөлт болж чадаагүй байна.

3.20 Төрийн албаны бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайланг гаргадаг хүний нөөцийн удирдлага мэдээллийн системийн програм нь өнөөгийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй байгаагаас төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тухай мэдээллийг тухай бүрт нь бодитой гаргах боломжгүй байна.

3.21 ТАЗСЗ-өөс бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан хүлээн авах, программд шивэх талаар сургалт зохион байгуулан арга зүйгээр ханган ажилласан гэх боловч тухайн байгууллагын мэдээлэл үнэн зөв, шинэчлэгдсэн мэдээллүүдэд засвар хийгдсэн эсэх, хүний нөөцийн үндсэн мэдээллүүдийн баяжилтыг хийж шинэ албан хаагчдыг бүртгэсэн байдал, албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний өөрчлөлтүүдийг нягтлах зэргээр тайланг шалгаж хүлээн авахдаа хариуцлагагүй хандсан байдал харагдаж байна.

3.22 ТАЗ-өөс төрийн байгууллага яам, агентлагт төрийн албаны хүний нөөцийн бодлогын төлөвлөлт хийх арга зүйгээр хангаж ажиллах талаар дутмаг байна.

Дүгнэлт:

- Улсын хэмжээнд 2013 оны эцсийн байдлаар 169448 ТАХ ажиллаж байгаа нэгдсэн дүн гарсан нь тухайн онд төсөвт батлагдсан 176773 орон тооноос 7325-аар дутуу байна.
- Төрийн албаны нэгдсэн тоо бүртгэлд 55 байгууллагын 3020 төрийн албан хаагчийн мэдээг тусгаагүй орхигдуулсан нь ТАЗСЗ-үүдийн ажлын хариуцлага зохион байгуулалт сул байсантай холбоотой байна.
- Ажил гүйцэтгэх гэрээгээр 1134 иргэн, давхар албан тушаал хашиж байгаа 2074 хүн яам, агентлаг төсөл хөтөлбөр, төрийн өмчит аж ахуйн нэгжийн төлөөлөн удирдах зөвлөлд ажиллаж байгааг бүртгэл мэдээллийн болон төрийн албаны ямар ангилалд хамруулах асуудлыг цэгцлэх шаардлагатай байна.
- ТАЗСЗ тухайн байгууллагын мэдээлэл үнэн зөв, шинэчлэгдсэн мэдээллүүдэд засвар хийгдсэн эсэх, хүний нөөцийн үндсэн мэдээллүүдийн баяжилтыг хийж шинэ албан хаагчдыг бүртгэсэн байдал, албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний өөрчлөлтүүдийг нягтлах зэргээр тайланг хүлээн авахдаа хариуцлагагүй хандсан дутагдал гарч байна.
- Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг гаргадаг хүний нөөцийн удирдлага мэдээллийн системийн програм нь өнөөгийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй, мэдээллийг шуурхай болгох боломж хомс байгааг шинэчлэх шаардлагатай байна.
- 2007 оноос хойш улсын хэмжээнд ТАХ-ийн тооллого явуулж бүртгэл, мэдээллийг үнэн зөв, цэгцтэй болгох ажил хийгдээгүй байна.

Холбогдох байгууллагын санал


МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ
15141 Улаанбаатар хот
Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн гудамж 11,
Утас: 264216, Факс: 264460

2014. 11. 28 № 7488

танай _____ -ны № _____ -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

“Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны үр дүн”-д танай байгууллагаас хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад холбогдох саналаа хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудас

ДАРГА  В.ЦОГОО



ҮАГ-ын
тайлбар 1-ийг
үзнэ үү

ҮАГ-ын
тайлбар 2-ыг
үзнэ үү

ҮАГ-ын
тайлбар 3-ыг
үзнэ үү

САНАЛ

Үндэсний Аудитын газраас "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөл түүнд тусгагдсан дүгнэлт, зөвлөмжийн талаар дараах саналыг хүргүүлж байна.

Нэг. Тайлангийн бичлэг, агуулгын илэрхийлэлийн талаар:

а. Тайлангийн 3 бүлгийн нэрийг аудитын 3 үндсэн зорилттой нийцүүлэн өөрчлөн найруулах,

б. II бүлгийн 2.3-г "Мэргэшлийн шалгалт, удирдах ажилтны сонгон шалгаруулалтад ороогүй иргэнийг төрийн албан тушаалд томилжээ" гэж өөрчлөн засах.

в. III бүлгийн 3.7 дахь хэсэгт дурдагдсан ТАХ-ын тоо мэдээний зөрүүний тухай асуудал хангалттай үндэслэлтэй биш тул түүнтэй холбоотой хавсралт №3 хүснэгтийг тайлангаас хасах,

г. Мөн бүлгийн 3.8-д "...3020 хүний мэдээг төрийн албаны ...нэгдсэн бүртгэл мэдээлэлд оруулаагүй орхигдуулсан зөрчил байна." гэдгийг "төрийн албаны аль ч ангилал, зэрэглэлд хамаардаггүй улсын төсөвт болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 3020 хүн төсвөөс цалинжиж байна." гэсэн агуулгаар өөрчлөн засах. Тиймээс хавсралт №4 гэсэн хүснэгтийг тайланд заавал хавсаргах шаардлагагүй юм гэж үзэж байна.

Хоёр. Бүлгийн дүгнэлтүүдийн агуулгыг багтаасан нэгдсэн дүгнэлтийг тайланд нэмж тусгана уу. Ингэхдээ нэгдсэн дүгнэлтэд:

-Аудит хийсэн 3 үндсэн чиглэлээр 2012, 2013 2014 онд Төрийн албаны зөвлөлөөс хийж гүйцэтгэсэн ажлын нааштай талыг тоймлон оруулах,

-Мөн зөрчил дутагдлын шалгасан болон Төрийн албаны зөвлөлийн шууд үйл ажиллагаанаас үл хамаарах хүчин зүйлийн нөлөөллийг дурдах,

-Төрийн албаны тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, төрийн албыг тогтвортой байлгах, төрийн албан хаагчдыг эрх ашиг, нийгмийн баталгааг хангахтай холбогдон гарч буй асуудалтай холбоотой санал дүгнэлтийг нэмж оруулна уу.

Гурав. Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилт нь дан ганц Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагаагаар бүрэн шийдэгдэхгүй, хууль тогтоох болон, гүйцэтгэх засаглалын дэмжлэг, хамтын ажиллагаа, улс төрийн албан хаагчдын хууль хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас ихээхэн хамааралтай байх тул тэдгээр субъектүүдэд хандсан зөвлөмж саналыг тайлангийн зөвлөмж хэсэгт нэмж тусгаж өгвөл Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагаанд өгөөж, ач холбогдолтой байх болно гэж үзэж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБА

Саналд өгсөн тайлбар

ҮАГ-ын тайлбар 1

Тайлангийн 3 бүлгийн нэр аудитын зорилттой уялдаж байгаа бөгөөд 2 дугаар бүлгийн 2.3 дах хэсгийг ТАЗ-ийн саналаар найруулгын өөрчлөлт хийв.

Тайлангийн 3.7 дах хэсэгтэй холбоотой хавсралт №3-ыг тайланд хавсаргах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлангийн 3.8 дах хэсэгт “ төрийн албаны аль ч ангилал, зэрэглэлд хамаардаггүй улсын төсөвт болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 3020 хүн төсвөөс цалинжиж байна” гэж найруулгын өөрчлөлт хийж хавсралт №4-ийг тайланд оруулаагүй болно.

ҮАГ-ын тайлбар 2

Тайлангийн 3 бүлэгт ТАЗ-өөс 2012, 2013 онд хийж гүйцэтгэсэн ажлын нааштай талыг тусгасан болно. Бүлэг бүрийн төгсгөлд дүгнэлт хийгдсэн учир нэгдсэн дүгнэлт байх шаардлагагүй байна.

Тайланд дурдагдсан төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг явуулахдаа холбогдох байгууллагууд хуулийн хүрээнд дутагдалтай ажиллаж, ажлын байрны тусгай шаардлагын талаар гарсан зөрчил нь ТАЗ-ийн үйл ажиллагаанаас шууд шалтгаалсан гэх үндэслэлгүй байна.

ҮАГ-ын тайлбар 3

Тайланд Засгийн газар болон холбогдох байгууллагад хандсан зөвлөмжийг нэмж оруулав.

Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Нэг. Ерөнхий сайдад

- Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийн хэрэгжилтийг дүгнэх, түүний хэрэгжилтийг эрчимжүүлж, тодорхой үр дүнд хүргэх бодлого, арга хэмжээ авах,
- Төрийн захиргааны төв байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг боловсруулах, батлуулахад хуульд заасны дагуу ТАЗ-ийн саналыг авч хамтарч ажиллах,
- Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг ТАЗ-тэй хамтран ТАТ хуулийн шаардлагын хүрээнд зохион байгуулж байх,
- Төрийн албаны тоо бүртгэлийн нэгдсэн мэдээлэл гаргах програм хангамжийн асуудлыг боловсронгуй болгох арга хэмжээ авах.

Хоёр. ТАЗ-ийн даргад

- Төрийн албаны тухай хуулийг шинэчлэх, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтны ажлын байранд тавигдах нийтлэг болон тусгай шаардлагыг УИХ-аар батлуулах, төрийн албаны хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх,
- Төрийн албаны зөвлөлөөс салбар зөвлөлүүдийн ажлын төлөвлөлт, чиг үүргийн хэрэгжилт, тайлагнал, түүний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, мэргэжил арга зүйгээр хангах,
- ТАХ-ийн иж бүрэн тооллого явуулж, төрийн албан хаагчийн тоо бүртгэл, мэдээллийн програм хангамж, нэгдсэн сүлжээний ашиглалтыг сайжруулах, мэдээллийн үнэн зөв, шуурхай байдлыг хангах арга хэмжээ авах,
- Төрийн жинхэнэ албаны болон удирдах ажилтны томилгоог хуульд нийцүүлэх, хууль бус шийдвэр гаргуулахгүй байх чиглэлээр ТАЗ болон ТАЗСЗ-ийн үйл ажиллагааг эрчимжүүлж, үр нөлөөг дээшлүүлэх.
- Төрийн албаны мэргэшлийн шалгалт, удирдах ажилтны сонгон шалгаруулалт, хууль бус томилгоотой холбоотой болон ТАТХ зөрчсөн асуудлаар эрх бүхий этгээдэд хариуцлага тооцуулж ажиллах.

Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 421

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны үр дүн"-д хийсэн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг УИХ-ын Төсвийн Байнгын хороо, ЗГХЭГ, ТАЗ-д тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг 2015 оны 6 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга С. Баярцогт, ТАЗ-ийн дарга Б.Цогоо нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын дарга С. Төмөрхүүд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

Аймаг, Нийслэлийн ТАЗ, ТАС3-ийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн нэгтгэл

Д/б	Аймаг, нийслэл	Дүгнэлт										Зөвлөмж						
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	
		ТАС3-ийн ажил үйл ажиллагаа хангалтгүй, ТАЗ түүнийг мэргэжил арга зүйтэй хангахгүй байна	Төрийн албаны шинэтэл, хүний нөөцийн боллогыг хэрэглэлт түүнд тавих хяналт хангалтгүй	Төрийн албаны хаачингийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан үнэн зөв гаргалгүй	ТАС3-д ТАТХ болон холбогдох хууль тогтоомжийн хэрэглэлт хангалтгүй	Эрх бүхий этгээд тухайн ажлын байрны тодорхойлолтыг албан тушаалтанд тохируулан баталдаг	Төрийн албаны мэргэшлийн шалгалтын бүртгэлийн хураамж түүний захиран зарцуулалтын эрх зүй орчин тодорхой бус	Төрийн албаны мэргэшлийн болон удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохинон байгуулаагүй	ТАС3 хуулиар хүлээсэн чиг үүрэг, эрхтэй хэрэг ажиллагаа сайжруулах шаардлагатай байна	ТА3, С3-ийг мэргэжил арга зүйтэй хангаж ажиллах шаардлагатай байна	Төрийн албаны шинэтэл, хүний нөөцийн боллогыг хэрэглэлт түүнд тавих хяналтыг сайжруулах	ТА3, ТАС3-ыг мэргэжил арга зүйтэй хангаж ажиллах	Төрийн албан хаагчдийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан боловсролгүй болгох	Ажлын байрны тодорхойлолтын шаардлагыг ТАЗ холбогдох журам, заавруудтай ийццүүлэн баталж, мөрдүүлэх	Шалгалтын хураамж, орлого, зарлагын эрх зүйн орчин сайжруулах шаардлагатай	Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэглэлт хангалтгүй	Шалгалтын хураамж, орлого, зарлагын эрх зүйн орчин сайжруулах шаардлагатай	
1	Архангай	✓			✓	✓		✓				✓						
2	Баян-Өлгий		✓															
3	Баянхонгор	✓		✓														
4	Булган	✓	✓															
5	Говь-Алтай																	
6	Говьсүмбэр																	
7	Дархан-Уул																	
8	Дорноговь	✓		✓														
9	Дорнод																	
10	Дундговь																	
11	Орхон																	
12	Өвөрхангай																	
13	Өмнөговь																	
14	Сүхбаатар																	
15	Сэлэнгэ	✓																
16	Төв		✓															
17	Увс																	
18	Ховд																	
19	Хөвсгөл																	
20	Хэнтий	✓	✓															
21	Завхан	✓																
22	Нийслэл	✓	✓															

Тайлбар "✓" гарсан зөвлөмжийн болон сайжруулах шаардлагатай асуудлыг тэмдэглэв.